

## ТАНИЛЦУУЛГА

Биеийн тамир, спортын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг “Мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй тамирчин, шүүгчид спортын цол олгоно.”, 11 дүгээр зүйлийн 11.3.8 дахь заалт “холбооны бүтэц, үйл ажиллагаа, зохион байгуулсан спортын тэмцээн, наадам, тамирчны амжилт, спортын цол, зэрэг, гишүүнчлэлээр мэдээллийн цахим сантай байх;”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Спортын төрөл, цолны шалгуур тогтоох, цол, зэрэг олгох журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан танилцуулж байна.

Дэлхий нийт технологийн эринд шилжиж байгаа өнөө үед түүгээр дамжуулан төрийн аливаа үйл ажиллагаа нь ил тод, түргэн шуурхай, хариуцлагатай, өндөр бүтээмжтэй, салбар хоорондын харилцан уялдаа холбоог хангасан цогц мэдээллийн систем бүхий цахим засаглалд шилжиж байгаа билээ.

Энэ удаагийн “Спортын төрөл, цолны шалгуур тогтоох, цол, зэрэг олгох журам”-ын төсөлд тухайн спортын холбоо нь олон улс болон дотоод тэмцээн, наадамд оролцсон, зохион байгуулсан тухай мэдээ мэдээллийг (тамирчдын бүртгэл, тэмцээний протокол, үр дүн, тайлан мэдээ болон бусад бичиг баримт) биеийн тамир, спортын нэгдсэн цахим санд байршуулснаар спортын цолны ангилал тогтоох төрөлд хамрагдахаар зохицуулалт хийгдсэн нь журмын гол шинэчлэл бөгөөд цаашлаад төр, төрийн бус байгууллагын хоорондын хамтын ажиллагаа сайжирч мэдээлэл /data/ солилцох үйл явц илүү хялбар, ил тод, түргэн шуурхай болоход ач холбогдолтой болно.

Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх заалтын хүрээнд “Спортын төрөл, цолны шалгуур тогтоох, цол, зэрэг олгох журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг та бүхэнд /спортын холбоод/ танилцуулж байна,

Журмын төсөлд тусгах саналаа 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор [bayarkhuu@sport.gov.mn](mailto:bayarkhuu@sport.gov.mn) цахим хаягаар илгээнэ үү.

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО

СПОРТЫН ТӨРӨЛ, ЦОЛНЫ АНГИЛАЛ ТОГТООХ,  
ЦОЛ, ЗЭРЭГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий үндэслэл

- 1.1 Монгол Улсад нийтлэг хөгжсөн болон биеийн тамир, спортын нэгдсэн цахим санд бүртгэлтэй спортын төрөл, тэдгээрийн цолны ангилал тогтоож, олгох үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2 Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төр, төрийн бус байгууллагын оролцоог хангасан спортын цолны ангилал тогтоох асуудлыг хэлэлцэх, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлтэй “цаашид Зөвлөл гэх” байна.
- 1.3 Биеийн тамир, спортын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэгт заасныг баримтлан тухайн жилийн улсын хэмжээний тэмцээний /улсын аварга шалгаруулах тэмцээн/ нэгдсэн хуваарийн жагсаалтад багтсан тэмцээнд оролцогчдод цол олгоно.
- 1.4 Спортын цолны ангилал тогтоох төрөлд хамрагдсан спортын холбоо нь тамирчин, шүүгчийн ёс зүйн дүрмийг олон улсын дүрэмд нийцүүлэн баталж, мөрдүүлнэ.
- 1.5 Спортын цолыг Монгол Улсын иргэнд олгоно.
- 1.6 Биеийн тамир, спортын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.8 дахь заалтыг үндэслэн тамирчин, шүүгчдэд спортын цолыг нөхөн олгож болно.

Хоёр. Спортын төрөл, цол, зэргийн ангилал

- 2.1 Дараах шаардлагыг хангасан спортын холбоод спортын цолны ангилал тогтоох төрөлд хамрагдана.
  - 2.1.1 Монгол Улсад нийтлэг хөгжсөн, тухайн спортын олон улсын болон дэлхийн холбоонд албан ёсны бүртгэлтэй, тэдгээр нь Дэлхийн допингийн эсрэг агентлагаар (WADA) хүлээн зөвшөөрөгдсөн;
  - 2.1.2 Монгол Улсын Засгийн газраас баталсан Допингийн эсрэг үндэсний дүрмийг дагаж мөрддөг байх;
  - 2.1.3 Олон Улс, Тив, Дэлхийн зэрэглэлийн болон дотоодын тэмцээн, наадамд оролцсон, зохион байгуулсан талаарх мэдээ, мэдээлэл нь (тамирчдын бүртгэл, тэмцээний протокол, үр дүн, тайлан мэдээ болон бусад бичиг баримт) биеийн тамир, спортын нэгдсэн цахим санд байршуулсан байх;
  - 2.1.4 Спортын нэг төрлөөр хоёроос дээш спортын холбоо үйл ажиллагаа явуулдаг бол энэхүү журмын 2.1.1 дэх хэсгийг баримтална;
- 2.2 Үндэсний уламжлалт болон бусад спортын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг спортын холбоод спортын цолны ангилал тогтоох төрөлд хамрагдахад дараах шаардлагыг харгалзан үзэж, зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн энэхүү журмын 3.1 дэх хэсэгт заасны дагуу олгоно.
  - 2.2.1 Дотоодын тэмцээн, наадамд оролцсон, зохион байгуулсан талаарх мэдээ, мэдээлэл нь (тамирчдын бүртгэл, тэмцээний протокол, үр дүн, тайлан мэдээ болон бусад бичиг баримт) биеийн тамир, спортын нэгдсэн цахим санд байршуулсан байх;
  - 2.2.2 Монгол Улсын 21 аймаг болон нийслэлийн хэмжээнд 70-аас дээш хувьд салбар холбоотой байх;

## ЖУРМЫН ТӨСӨЛ ОЛОН НИЙТЭД /СПОРТЫН ХОЛБООДОД/ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ

2.2.3 Жил бүр улсын аварга шалгаруулах тэмцээн тогтмол зохион байгуулдаг байх;

2.1 Спортын холбоо нь “Спортын цолны нэгдсэн ангилал”-д хамрагдах, нэмэлт өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг батлагдсан маягт (хүснэгт)-ын дагуу тухайн оны 11 дүгээр сарын 15-ны дотор Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

2.2 Спортын цолны нэгдсэн ангиллыг зөвлөлийн хурлын дүгнэлтийг үндэслэн Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага баталж, дараа оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2.3 Тухайн спортын төрөл нь спортын цол, зэргийн нэг ангилалтай байна.

2.4 Тамирчин, шүүгчдэд олгох спортын цол, зэрэг нь дараах ангилалтай байна.

2.4.1 Цол:

- 2.4.1.1 Спортын дэд мастер
- 2.4.1.2 Спортын мастер
- 2.4.1.3 Олон улсын хэмжээний мастер

2.4.2 Зэрэг:

- 2.4.2.1 3 дугаар зэрэг
- 2.4.2.2 2 дугаар зэрэг
- 2.4.2.3 1 дүгээр зэрэг

2.5 Шүүгчдэд олгох цол, зэрэг нь дараах ангилалтай байна.

2.5.1 Цол

- 2.5.1.1 Улсын шүүгч

2.5.2 Зэрэг

- 2.5.2.1 Шүүгч

2.6 Цол олгох ангилал тогтоохдоо дараах шалгуурыг баримтална. Үүнд:

2.6.1 Олон улсын хэмжээний мастер цолыг Олимп, Паралимп, тивийн наадам, тив, дэлхийн зэрэглэлийн тэмцээний амжилт,

2.6.2 Спортын мастер цолыг Үндэсний хэмжээний спортын наадам, Улсын аварга шалгаруулах тэмцээн, лигийн тэмцээнд үзүүлсэн амжилт,

2.6.3 Спортын дэд мастер цолыг Үндэсний хэмжээний спортын наадам, улсын аварга шалгаруулах тэмцээн, лигийн тэмцээнд үзүүлсэн амжилт,

2.6.4 Улсын шүүгч цолыг улс, олон улсын чанартай тэмцээнийг шүүсэн туршлага, шүүгчийн мэргэжлийн сургалтад хамрагдсан байдал, холбооны шүүгчийн зөвлөлийн шалгалтын дүн, шийдвэрийг;

2.6.5 Зэргийг Улсын аварга шалгаруулах тэмцээн, аймаг, нийслэл, хотын аварга шалгаруулах тэмцээн, нэрэмжит тэмцээн, спортын холбооноос гаргасан чансаа, зэрэглэлийг;

2.6.6 Зэрэг олгох шалгуурыг тухайн спортын холбоо тогтооно.

Гурав. Спортын цол, зэрэг олгох

3.1 Биеийн тамир, спортын нэгдсэн цахим сангийн мэдээллийг үндэслэн спортын цолны ангиллын шалгуур хангасан тамирчин, шүүгчдэд сар бүрийн 25-ны дотор даргын тушаалаар баталж цолны үнэмлэх, тэмдэг олгоно.

3.2 Спортын цолны үнэмлэх, тэмдгийг үнэ төлбөргүй олгоно.

## ЖУРМЫН ТӨСӨЛ ОЛОН НИЙТЭД /СПОРТЫН ХОЛБООДОД/ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ

- 3.3 Спортын цолны тэмдэг, үнэмлэхийг үрэгдүүлсэн тохиолдолд биеийн тамир, спортын нэгдсэн цахим сангийн мэдээллийг үндэслэн нэг удаа олгоно.
- 3.4 Спортын зэргийг тухайн спортын холбоо олгох ба аймаг, нийслэлд үйл ажиллагаа эрхэлдэг салбар холбоо болон Биеийн тамир, спортын газар, хороогоор дамжуулан гэрээний дагуу гүйцэтгүүлж болно.
- 3.5 Тухайн спортын холбоо нь нэрээ өөрчилсөн тохиолдолд /хуулийн этгээдийн нэршил/ 30 хоногийн дотор шинэчилсэн мэдээллээ Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлж, энэхүү журмын 2.3 дагуу шийдвэрлүүлнэ.

### Дөрөв. Спортын цол, зэргийн ангилал тогтоох зөвлөл

- 4.1 Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хуралдаан нь ээлжит ба ээлжит бус хэлбэртэй байна. Ээлжит хуралдаан жил бүрийн 12 дугаар сарын эхний долоо хоногт, шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг зөвлөлийн даргын зарласнаар тухайн хугацаанд хуралдаж, хэлэлцсэн асуудлын талаар санал хурааж олонхын саналыг үндэслэн дүгнэлт гаргана.
- 4.2 Зөвлөл нь Биеийн тамир, спортын хорооны болон биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий 9 хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 4.3 Спортын холбооноос энэ журмын 2.1.3-т заасан мэдээллийг алдаатай оруулсны улмаас тамирчин, шүүгчдэд олгогдсон цол болон тухайн спортын төрлийн цолны ангиллыг хүчингүй болгох асуудлыг Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, дүгнэлт гарган Биеийн тамир, спортын төрийн захиргааны байгууллагын даргад танилцуулж шийдвэр гаргуулна.
- 4.4 Зөвлөлийн дарга нь Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, нарийн бичгийн дарга нь Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын спортын цол, зэргийн асуудал хариуцсан мэргэжилтэн байна.

### Тав. Бүртгэл, мэдээлэл

- 5.1 Спортын цол олгосон талаарх мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг спортын холбоо болон зөвлөлийн нарийн бичгийн дарга нар тус тус хариуцна.
- 5.2 Спортын зэрэг олгосон талаарх мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг тухайн спортын холбоо хариуцна.
- 5.3 Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь шинээр цолны шалгуур хангасан тамирчин, шүүгчдийн мэдээллийг [www.sport.gov.mn](http://www.sport.gov.mn) болон “ХҮР” төрийн мэдээлэл солилцооны системээр дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлнэ.





СПОРТЫН ТӨРӨЛ, ЦОЛ, ЗЭРГИЙН НЭГДСЭН ШАЛГУУР

Спортын төрөл

| №  | Тэмцээний төрөл                    | Ганцаарчилсан төрөл               |    |                 |    | Багийн төрөл        |    |                 |    | Эзэлсэн байр |       |       | цол  |  |  |  |  |  |     |
|----|------------------------------------|-----------------------------------|----|-----------------|----|---------------------|----|-----------------|----|--------------|-------|-------|------|--|--|--|--|--|-----|
|    |                                    | Жин, Зай тус бүрт оролцогчдын     |    |                 |    | Оролцсон багийн тоо |    |                 |    | Алт          | Мөнгө | Хүрэл |      |  |  |  |  |  |     |
|    |                                    | Залуучууд                         |    | Насанд хүрэгчид |    | Залуучууд           |    | Насанд хүрэгчид |    |              |       |       |      |  |  |  |  |  |     |
|    |                                    | Эр                                | Эм | Эр              | Эм | Эр                  | Эм | Эр              | Эм |              |       |       |      |  |  |  |  |  |     |
| 1  | Олимпын наадам                     | Оролцогчдын тоо хамаарахгүй       |    |                 |    |                     |    |                 |    |              |       |       | ОУХМ |  |  |  |  |  |     |
| 2  | Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн |                                   |    |                 |    |                     |    |                 |    |              |       |       |      |  |  |  |  |  |     |
| 3  | Дэлхийн наадам                     |                                   |    |                 |    |                     |    |                 |    |              |       |       |      |  |  |  |  |  |     |
| 4  | Универсиад                         |                                   |    |                 |    |                     |    |                 |    |              |       |       |      |  |  |  |  |  |     |
| 5  | Азийн наадам                       |                                   |    |                 |    |                     |    |                 |    |              |       |       |      |  |  |  |  |  |     |
| 6  | Олон улсын тэмцээн                 |                                   |    |                 |    |                     |    |                 |    |              |       |       |      |  |  |  |  |  |     |
| 7  | Монголын бүх ард түмний наадам     | Оролцогчдын /баг/ тоо хамаарахгүй |    |                 |    |                     |    |                 |    |              |       |       | СМ   |  |  |  |  |  |     |
|    |                                    |                                   |    |                 |    |                     |    |                 |    |              |       |       |      |  |  |  |  |  | СДМ |
| 8  | Оюутны спортын их наадам           | Оролцогчдын /баг/ тоо хамаарахгүй |    |                 |    |                     |    |                 |    |              |       |       | СМ   |  |  |  |  |  |     |
|    |                                    |                                   |    |                 |    |                     |    |                 |    |              |       |       |      |  |  |  |  |  | СДМ |
| 9  | Лигийн тэмцээн                     | Оролцогчдын /баг/ тоо хамаарахгүй |    |                 |    |                     |    |                 |    |              |       |       | СМ   |  |  |  |  |  |     |
|    |                                    |                                   |    |                 |    |                     |    |                 |    |              |       |       |      |  |  |  |  |  | СДМ |
| 10 | Улсын аварга шалгаруулах тэмцээн   |                                   |    |                 |    |                     |    |                 |    |              |       |       | СМ   |  |  |  |  |  |     |
|    |                                    |                                   |    |                 |    |                     |    |                 |    |              |       |       |      |  |  |  |  |  | СДМ |
| 11 | Бусад                              |                                   |    |                 |    |                     |    |                 |    |              |       |       |      |  |  |  |  |  |     |

Тайлбар:

- Улсын шүүгч цолны шалгуур бүх спортын төрөлд хамаарна. /хуучнаар/ Тэмцээнд оролцогчын тоог сүүлийн 4-5 удаагийн улсын аварга шалгаруулах болон бусад тэмцээнд оролцогчдын дунджаар гаргах

-  Оролцогчдын тоо
-  Эзэлсэн байр, медаль, оноо
-  Тэмцээний төрөл /цолны ангилалд хамрагдах тэмцээн, наадам/
-  Спортын цол